



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МАНДАЛ ЭНЕРГО ОНӨААТҮГ-ЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: СЭА-2024/20/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК

Захирал: Х.Ариунзул

Утас: 99077062 Цахим хаяг: ikhnayadaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....	8
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	8
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	10
4. Аудитын тайлан.....	11
4.1 Ерөнхий зүйл.....	11
4.2 Материаллаг байдал.....	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
5. Аудитын илрүүлэлт.....	13
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	0

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТБОНОХБАХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.3.15 № САА-2024/20-НА-СТА-099
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Мандал энерго” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Мандал энерго” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Мандал энерго” ОНӨААТҮГ нь гүйцэтгэлээр 1,577,571.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,560,044.4 мянган төгрөгийн зардал гарган, 17,526.8 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

“Мандал Энерго” ОНӨААТҮГ нь 2018 онд байгууллагын даргын тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Уг бодлогын баримт бичгийг баталж, хэрэгжүүлж эхэлснээс хойш “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” болон бусад холбогдох хууль эрхийн актуудад хийгдсэн шинэчилсэн найруулга, нэмэлт өөрчлөлтүүдтэй нийцэхгүй байна.

Жилийн эцэст өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулж сумын онцгой комиссын шийдвэрийн дагуу аюулгүй ажиллагааг хангах зорилгоор 1 сарын хэрэглээний

нүүрсийг зээлээр худалдан авч, нөөц үүсгэснээс шалтгаалж өмнөх оноос бараа материалын дансны үлдэгдэл 153,716.7 мянган төгрөгөөр, богино хугацаат өр төлбөр 91,356.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн бөгөөд татварын өмнөх ашгийн төлөвлөгөө 19,121.1 мянган төгрөгөөр тасарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Бусад асуудлын хэсэгт аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,559,058.58	18,428,863.75
1.1.2	Дансны авлага	62,68,528.83	49,508,091.18
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	2,055,069.50	1,829,671.08
1.1.4	Бусад авлага	5,229,622.31	4,705,541.00
1.1.6	Бараа материал	65,444,456.98	219,161,174.03
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	900,000.00	671,723.51
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	140,156,736.20	294,305,064.55
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,059,193,591.55	879,137,101.54
1.2.2	Биет бус хөрөнгө	5,049,000.00	3,861,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,064,242,591.55	882,998,101.54
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,204,399,327.75	1,177,303,166.09
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	35,784,584.01	102,130,860.98
2.1.1.2	Цалингийн өглөг	427,787.05	489,576.00
2.1.1.3	Татварын өр	42,001,995.02	48,498,575.69
2.1.1.4	НДШ-ийн өглөг	500,000.00	18,332,064.04
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	7,542,633.14	8,162,839.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	86,256,999.22	177,613,915.71
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	86,256,999.22	177,613,915.71
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-хувийн	250,535,268.80	250,535,268.80
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,632,360.38	2,632,360.38
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,038,079,161.91	903,851,934.74
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(173,104,462.56)	(157,330,313.54)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	-	15,774,149.02
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	(173,104,462.56)	(173,104,462.56)
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,118,142,328.53	999,689,250.38
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,204,399,327.75	1,177,303,166.09

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,160,770,994.92	1,577,571,221.81
2	Борлуулалтын өртөг	1,016,429,216.37	1,357,092,082.80
3	Нийт ашиг(алдагдал)	144,341,778.55	220,479,139.01
10	Ерөнхий ба удирдлагын зардал	107,458,467.54	149,442,326.60
12.1	Зардлын дүн	107,458,467.54	149,442,326.60
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(8,524,956.72)	(49,452,413.28)
17	Бусад ашиг (алдагдал)	(8,340,382.51)	(4,057,566.89)
17.1	Олз гарзын дүн	(16,865,339.23)	(53,509,980.17)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	20,017,971.78	17,526,832.24
19	Орлогын татварын зардал	200,179.72	1,752,683.22
20	Татварын дараах ашиг (алдагдал)	19,817,792.06	15,774,149.02
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	19,817,792.06	15,774,149.02

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	250,535,268.80		1,037,427,343.73	(165,878,669.28)	1,122,083,943.25
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				(27,043,585.34)	(27,043,585.34)
Өмчид гарсан өөрчлөлт			651,818.18		651,818.18
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		2,632,360.38			2,632,360.38
Залруулсан үлдэгдэл	250,535,268.80	2,632,360.38	1,038,079,161.91	(192,922,254.62)	1,098,324,536.47
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				19,817,792.06	19,817,792.06
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	250,535,268.80	2,632,360.38	1,038,079,161.91	(173,104,462.56)	1,118,142,328.53
Өмчид гарсан өөрчлөлт			(134,227,227.17)		(134,227,227.17)
Залруулсан үлдэгдэл	250,535,268.80	2,632,360.38	903,851,934.74	(173,104,462.56)	983,915,101.36
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				15,774,149.02	15,774,149.02
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	250,535,268.80	2,632,360.38	903,851,934.74	(157,330,313.54)	999,689,250.38

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,309,822,240.65	1,867,984,561.83
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,277,329,173.65	1,781,116,610.09
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,089,775.00	576,077.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	31,403,292.00	86,291,874.74
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,220,818,073.82	1,851,234,851.66
1.2.1	Ажиллагчдад төлсөн	284,740,852.41	406,163,543.81
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	82,242,628.10	114,460,183.88
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	447,757,215.86	167,145,820.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	149,930,754.32	174,734,255.04
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	109,72,173.06	709,080,598.26
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	87,203,496.41	113,243,107.58
1.2.9	Бусад мөнгөн зарлага	60,030,652.52	166,407,343.09
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	89,004,166.83	16,749,710.17
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн	87,153,800.00	1,879,905.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	81,213,800.00	1,879,905.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,940,000.00	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(87,153,800.00)	(1,879,905.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,850,366.83	14,869,805.17
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,753,691.75	3,559,058.58
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,559,058.58	18,428,863.75

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мян.төг/

№	Зардлын төрөл		2023 оны		Зөрүү	Хувь
			Төсөв	Гүйцэтгэл		
1	Цалингийн зардал		531,693.2	524,178.7	7,514.50	98.6
2	НДШ-ийн зардал		77,095.5	74,898.5	2,197.00	97.2
3	Түүхий эд материал		483,641.6	485,454.8	(1,813.20)	100.4
4	Гэрэл цахилгаан		61,526.3	72,186.0	(10,659.70)	117.3
5	Цэвэр ус худалдан авах зардал		64,241.0	71,635.7	(7,394.70)	111.5
6	Шатах тослох материал		60,460.7	66,325.9	(5,865.20)	109.7
7	Тээврийн зардал	МБУ /нэвтрэх хөлс/	38,683.5	2,965.0	(1,539.50)	99.6
		БАУ-1 анги /Зам ашиглалт/		14,460.0		
		УБТЗ өртөө /таталт тавилтын хөлс/		10,525.5		
		Нүүрс буулгалтын зардал		7,200.0		
		Нүүрс ачилт түрэлтийн хөлс		5,072.5		
8	Шуудан холбоо		3,572.5	2,873.8	698.70	80.4
9	Албан томилолт		1,950.0	369.3	1,580.70	18.9
10	Бичиг хэргийн зардал		1,808.3	1,584.3	224.00	87.6
11	Сэлбэгийн зардал		2,517.0	3,104.0	(587.00)	123.3
12	Төлбөр хураамжийн зардал		361.4	392.5	(31.10)	108.6
13	Усны шинжилгээний зардал		1,676.0	1,296.1	379.90	77.3
14	ҮХ-ийн элэгдлийн зардал		78,480.4	78,209.9	270.50	99.7
15	Аудит, Тусгай зөвшөөрлийн төлбөр		5,962.7	6,004.1	(41.40)	100.7
16	Татвар, даатгалын зардал		2,230.3	436.9	1,793.40	19.6
17	Нэг удаагийн тэтгэмж шагнал		16,050.9	16,050.9	-	100.0
18	Бага үнэтэй түргэн хэрэглэгдэх зүйл		5,176.9	5,177.0	(0.10)	100.0
19	Жижиг эд хогшил-багаж хэрэгсэл		10,650.0	10,124.3	525.70	95.1
20	Хангамжийн материал, засвар		12,615.5	16,999.3	(4,383.80)	134.7
21	ХАБЭА-н зардал		11,821.5	11,514.0	307.50	97.4
22	Цэвэрлэгээ ариутгалын зардал		3,230.1	2,994.8	235.30	92.7
23	Их засвар зуух		3,172.0	3,087.1	84.90	97.3
24	Ажлын байрны нөхцөл тодорхойлуулах		2,512.0	2,500.0	12.00	99.5
25	Орчны шинжилгээ хийлгэх		600.0	600.0	-	100.0
26	Хог хаягдлын зардал		0.0	935.0	(935.00)	-
27	Ажилчдын нийгэм хангамжийн		3,100.0	2,761.7	338.30	89.1
28	Сургалт, спорт арга хэмжээний зардал		1,550.0	1,580.0	(30.00)	101.9
29	Үндсэн бус үйл ажиллагааны зардал		2,000.0	1,284.2	715.80	64.2
30	Орлогын татвар			1,752.7		-
31	МБТөв үндсэн хөрөнгө шилжүүлсэн гарз			53,509.9	(53,509.90)	-
БАЙГУУЛЛАГЫН НИЙТ ЗАРДАЛ			1,488,379.3	1,560,044.4	(69,912.40)	
1	Дулааны борлуулалтын орлого		1,388,744.1	1,410,036.2	(21,292.10)	101.5
	Дулааны хэсгийн бусад орлого		11,627.3	26,292.2	(14,664.90)	226.1
	Нүүрсний орлого			11,912.7	(11,912.70)	-
2	УХАТ- цэвэр ус борлуулалтын орлого		110,764.9	113,567.5	(2,802.60)	102.5
	УТБ-ны усны борлуулалтын орлого		8,365.5	10,560.0	(2,194.50)	126.2
	Засвар үйлчилгээний орлого		5,525.5	5,202.6	322.90	94.2
ОРЛОГЫН ДҮН			1,525,027.3	1,577,571.2	(52,543.90)	
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ+, АЛДАГДАЛ -			36,648.0	17,526.8	19,121.20	47.8
1	Худгийн цахилгаан халаагуур		4,950.0	0.0	4,950.00	-
2	Төв шугамын засвар		49,108.1	51,107.7	(1,999.60)	104.1
3	Нүүрс буулгах талбай цутгах		5,927.0	5,945.4	(18.40)	100.3
4	Зуухны их засвар		9,041.3	10,825.5	(1,784.20)	119.7
5	Утааны суваг шинэчлэх		5,940.0	3,163.6	2,776.40	53.3
6	Зуухны шахах шугам		26,652.8	26,207.7	445.10	98.3
Хөрөнгө оруулалтын нийт дүн			101,619.2	97,249.9	3,924.20	95.7

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

"Мандал Энерго" ОНОААТҮГ нь "Мандал сумын төвийн хэсгийн хэрэглэгчдийг ажиллах амьдрах тав тухтай нөхцөлөөр хангаж ажиллах" гэсэн зорилт тавин ажиллаж байна.

"Мандал Энерго" ОНОААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулаан үйлдвэрлэх, түгээх,
- Цэвэр ус дамжуулан борлуулах.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал бөгөөд 100.0 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

"Мандал Энерго" ОНОААТҮГ нь Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль Нийгмийн даатгалын багц хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТБОНӨХБАУХА тухай хууль, Эрчим хүчний тухай хууль зэрэг хуулиудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Мандал Энерго" ОНОААТҮГ -ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

"Мандал Энерго" ОНӨААТҮГ нь 2018 онд байгууллагын даргын тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн 2018 оноос хойш "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-д болон бусад холбогдох хууль, эрхийн актуудад шинэчилсэн найруулга, нэмэлт өөрчлөлтүүд хийгдсэн тул эдгээр өөрчлөлтүүдэд нийцүүлэн бодлогын бичиг баримтыг шинэчлэн боловсруулах нь зүйтэй юм.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

"Мандал Энерго" ОНОААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27,396.1 төгрөгөөр буюу 2.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,559.1	18,428.9	14,869.8
Авлага	70,253.1	56,043.3	(14,209.8)
Бараа материал	65,444.5	219,161.2	153,716.7
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	900.0	671.7	(228.3)
Үндсэн хөрөнгө	1,059,193.6	879,137.1	(180,056.5)
Биет бус хөрөнгө	5,049.0	3,861.0	(1,188.0)
Нийт хөрөнгө	1,204,399.3	1,177,303.2	(27,096.1)
Богино хугацаат өр төлбөр	86,257.0	177,613.9	91,356.9
Эздийн өмч	1,118,142.3	999,689.3	(118,453.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,204,399.3	1,177,303.2	(27,096.1)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 18,428.9 мянган төгрөг болж 14,869.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилийн үндсэн үйл ажиллагааны орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Авлага дансны үлдэгдэл 56,043.3 мянган төгрөг болж 14,209.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд усны авлагыг барагдуулснаас голлон

шалтгаалсан байна. Нийт авлагын 6.3 хувийг буюу 3,585.1 мянган төгрөгийг усны, 73.4 хувийг буюу 41,646.8 мянган төгрөгийг халаалтын, 7.8 хувийг буюу 4,405.5 мянган төгрөгийг бусад, 3.9 хувийг буюу 2,193.0 мянган төгрөгийг сууц өмчлөгчдийн, 3.2 хувийг буюу 1,829.7 мянган төгрөгийг татварын, 2.7 хувийг буюу 1,522.5 мянган төгрөгийг худгийн картны, 1.7 хувийг буюу 971.7 мянган төгрөгийг ажилчдаас авах, 1.0 хувийг 560.7 мянган төгрөгийн засварын авлага эзэлж байна.

- Сумын онцгой комиссын шийдвэрийн дагуу аюулгүй ажиллагааг хангах зорилгоор 1 сарын нүүрсний нөөц илүү үүсгэснээс шалтгаалсан бараа материалын дансны үлдэгдэл 219,161.2 мянган төгрөг болж, 153,716.7 мянган төгрөгөөр өссөн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 879,137.1 мянган төгрөг болж 180,056.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 15,463.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, 76,073.4 мянган төгрөгийн бусад хөрөнгө өөрөө үйлдвэрлэж /цахилгааны шугам/, Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 107 дугаар тогтоолын дагуу 299,293.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн данс бүртгэлээс хасаж, тайлант онд 87,913.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос шалтгаалсан байна.
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 177,613.9 мянган төгрөг болж 91,356.9 мянган төгрөгөөр өссөн нь нүүрс нөөцөлж, зээлээр худалдан авалт хийснээс байгууллагад өгөх өглөг буюу нүүрсний төлбөр 66,346.3 мянган төгрөгөөр, татварын өр төлбөр 6,496.6 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Нийт өр төлбөрийн 10.3 хувийг буюу 18,332.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн, 27.4 хувийг буюу 48,498.6 мянган төгрөгийн татварын, 57.4 хувийг буюу 102,130.9 мянган төгрөгийн дансны, 4.7 хувийг буюу 8,162.8 мянган төгрөгийг бусад, 0.2 хувийг буюу 489.6 мянган төгрөгийн цалингийн өр төлбөр эзэлж байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу "Мандал Энерго" ОНОААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

"Мандал Энерго" ОНОААТҮГ-ын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулж, тайлант оны нийт орлогыг 1,525,027.3 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,488,379.3 мянган төгрөгөөр, ашгийг 36,648.0 мянган төгрөгөөр төсөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,577,571.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,560,044.4 мянган төгрөгийн зардал гарган, 17,526.9 мянган төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,577,571.2 мянган төгрөг болж төлөвлөснөөс 52,543.9 мянган төгрөг буюу 3.4 хувиар давсан нь халаалтын орлого 1,407,055.0 мянган төгрөг, усны орлого 113,561.2 мянган төгрөг, үйлчилгээ шинжилгээний орлого 26,060.2 мянган төгрөг, худгийн усны орлого 10,560.0 мянган төгрөг, засвар

үйлчилгээний орлого 8,422.1 мянган төгрөг, борлуулсан нүүрсний орлого 11,912.7 мянган төгрөг зэрэг нийт 1,577,571.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 1,560,044.4 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 67,348.9 мянган төгрөг буюу 4.5 хувиар хэтэрсэн байгаа нь төлөвлөгдөөгүй нүүрсний нөөц үүсгэснээс голлон шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот тувшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу "Мандал Энерго" ОНОААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд "Мандал Энерго" ОНӨААТҮГ түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Их наяд Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Мөнхзул, аудитор М.Энхтуул нар гүйцэтгэж, хяналтыг захирал, чанарын хяналтын менежер Х.Ариунзул, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

"Мандал Энерго" ОНОААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангаа Их наяд аудит ХХК-д 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/43 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож 1,140,953.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,409.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

1.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 376.967.3 мянган төгрөгийн орлогын 27 гүйлгээ, 64.970.1 мянган төгрөгийн зарлагын 19 гүйлгээ мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд нүүрс худалдан авах 473,794.7 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй учраас “Шивээ овоо” ХХК-тай шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Мандал энерго” ОНӨААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,*
- *Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан гэх мэт.*

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагад 32 арга хэмжээг түүвэрлэн шалгахаар төлөвлөн хэрэгжүүллээ. Аудитын явцад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой судалгааг авч санхүүгийн аудитын системд оруулсан бөгөөд ямар нэгэн алдаа, зөрчил илрээгүй.

1.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөг, цалин, орлогын дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 22,883.2 мянган төгрөгийн 5 алдаа илэрснээс 2 зөвлөмж өгч, 3 алдааг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үзэхэд алдааг залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 9,978.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	9,978.0	1	9,978.0	100.0
Нийт дүн	1	9,978.0	1	9,978.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгийн тооллого хийж, биет тест хэрэгжүүлэх горимыг бүрэн хэрэгжүүлээгүй учир дараагийн аудитаар тулган шалгах нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,883.2 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулаа.

Залруулсан алдаа:

- Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ 22,692.3 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримтыг дутуу бүрдүүлсэн,
- Авлага, өр төлбөрийн үлдэгдэлгүй боловч журналд тусгахдаа харилцагчийг буруу сонгож илүү, дутуу илэрхийлсэн,
- Хангамжийн материалд бүртгэх 190.9 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.

Аудитаар 2 зөрчил² илэрч зөвлөмж өгсөн.

5.3 Зөвлөмж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил болон орлогын албан татвараар тооцох суурь хоорондын зөрүүгийн тайлан гаргаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2020 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 144 дүгээр тушаал “Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам”-ын 1.4 дэх “Тайлант хугацаанд хүлээн зөвшөөрсөн орлого, зардал, олз, гарз, хөрөнгө ба өр төлбөрийн ажил гүйлгээний тухайн тайлант хугацааны бус харин ирээдүйн тайлант хугацааны татвар ногдуулах орлогын дүнд нөлөө үзүүлэхээр байвал балансын өр төлбөрийн аргыг ашиглан хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрнө” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын суурь болох ашиглалтын жилээс багаар тооцсон тохиолдолд элэгдлийн зардлын хүлээн зөвшөөрөх дүнг балансын өр төлбөрийн аргыг ашиглан хойшлогдсон татвараар хүлээн зөвшөөрч бүртгэх

2. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд дулааны үнэ тариф шинэчлэгдэж, нэмэгдсэн үнээр борлуулалт хийгдсэн боловч айл, өрхийн болон албан байгууллагуудын дулаан хангах гэрээнд өөрчлөлт оруулж, шинэчилж хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалт болон аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн “Тарифт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 16 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Үнэ тарифын өөрчлөлт орсон тухай бүрт хэрэглэгчийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 01 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заруулсан		Заруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн цахим баримтыг дутуу бүрдүүлсэн.	1	22,692.3			1	22,692.3							
Авлага, өр төлбөрийн үлдэгдэлгүй боловч журналд тусгахдаа харилцагчийг буруу сонгож илүү дутуу илэрхийлсэн байна.	1	-			1	-							
Хангамжийн материалд бүртгэх бараа материалыг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн	1	-			1	190.9							
Дүн	3	22,692.3			3	22,883.2							

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс			
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага
					Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

	Тоо	Дүн										
	Тоо	Дүн										
Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил орлогын албан татвараар тооцох суурь хоорондын зөрүүгийн тайлан гаргаагүй	1	-					1	-				
Шинэчлэгдсэн үнэ тарифын өөрчлөлтийг мөрдөж, хэрэглэгчдийн гэрээнд өөрчлөлт оруулаагүй.	1	-					1	-				
Дүн	2	-					2	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 376.967.3 мянган төгрөгийн орлогын 27 гүйлгээ, 64.970.1 мянган төгрөгийн зарлагын 19 гүйлгээ мэдээлээгүй	1	-			1	-
Дүн	1				1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн	1	-			1	-